

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бавуугийн Содном	Дугаар	1036
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сонгинохайрхан дүүрэг
Төрсөн газар	Дундговь аймгийн Төгрөг сум	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Төгрөгийн жас	Сүм хийдийн дугаар	ДУСО 011
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	УВ 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Төгрөгийн жас
Дундговийн Төгрөгийн хийдэд сууж байсан. Манай сум татан буугдсан юм. Би 5 настайдаа суугаад 14 настай байхад багш минь баригдаад явсан. Би Би гэртээ шоголтой номоо үүрээд уйлаад ирж байсан. Манай эцэг одоо яахав цаг ийм болсон хойно уйлах юу байхав, уг нь миний хүү лам л явах ёстой хүн гэж байсан даа. Би эхээс зургуул. Манай эцэг хошууны ноён байсан. Цэрэгт явсан. Жолооч хийж байсан. 1990 онд Дашчойлин хийдийг байгуулагдахад хэдэн өвгөн лам нийлж хураад одоо болтол хурж л байгаа юм.

Төгрөгийн сүм нь Донид гүний хошууны Дуган ус гэдэг газарт байсан. Тэр хошууны ноён Равдан бэйс ноён гэж манай эцгийн эцэг байсан. Одоогоор бол Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт байсан. Хийд байсан газраа тахиж Цогчэн дуганын суурин дээр нь Намжил гэдэг хүн суварга босгосон. Намжил гуай надаас ах хүн. Төгрөгийн хийдэд сууж байсан. Мөн Эрдэнэдалайд Чогдонгийн Намсрай гэдэг хүн бий. Манай хурал

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байснаас урд Төгрөг хайрхан гэж бий. Төгрөгийн их овоо гэж бий. Төгрөгийн их овоог манай ноён ажаа буюу хошуу ноёны тахилгатай овоо байсан. Баруун талд нь Бадрах овоо гэж бий. Тэрүүхэн тэр дэнж дээр нэг цагаан дэрс байдгийн Гандай дэрс гэж нэрлэдэг. Янз бүрийн ханиад томуу гарахад тийшээ очиж сор залдаг байсан юм.

Хэдэн онд байгуулагдсаныг нь мэдэхгүй. Манайх 100 гаран ламтай, 4,5 н дугантай. Цогчэн, сахиусны дуган гэж байсан. Хийдийн гол шүтээн нь Лхам, Гомбо, Чойжоо. Хийдийн ловон нь Билэгсайхан гэж ловон байсан. Миний багш байсан. Гэсгүй нь Дугаа байсан. Дугар буюу Дугаа гуай эхлээд унзад байсан. Тэгээд гэсгүй болсон. Унзад нь Дондог гэдэг хүн байсан.

Цогчэндоо өдөр тутам цогчэн хурлаа таслахгүй хурна. Шинийн 8-нд Манла, 15-нд Сандуйн жүд, Найдан чоги, 29-нд Гомбо, Лхам, Чойжоо сахиус хурна. Цагаан сараар Цэдор Лхам, Ерөөлүүд хурна, 29-нд сор зална. Цагаан сарын өмнө адислага гээд бий. Мөн дуганын 360 хоносон балингуудыг шинэчлэдэг. Хуучин балингуудыг хурааж аваад адислаганд тараадаг. Бурхан багшийн дүйчэн өдрөөр, Богд ламын дүйчэн өдрөөр чогууд хурна. Манайд цам гардаггүй байсан. Намар Майдар эргэнэ. Зун, намрын цагт Ганжуур нутгаараа эргэж явдаг. Цаг үеэсээ хамаарч эргэнэ. Хайлан хийдэг байсан. Хайланд 10-аас дээш лам суудаг байсан. Намар 45 хоног хийнэ. Нүгнээ сахина. Болж л өгвөл сахина. Ер нь ламыг жинхэнэ дэг жаягтай болгохын тулд их сахиулдаг байсан. Жилд 2, 3 удаа нүгнээ сахина. Ер нь тэгээд цаг бусын үхэл зовлон энэ тэр болоход нүгнээ сахина.

Модоор бас хөх тоосгоор баригдсан хятад маягийн дуганууд байсан. Манайд ямар нэгэн сургалтын дацан байгаагүй. Манайхтай ойролцоо Далайн хийд байсан. Тэнд очиж цам их үздэг байсан. Манай хийдийн туурь одоо бараг мэдэгдэхгүй болсон байна лээ. Элсэнд дарагдаад.

Лам нар нь хийдийнхээ ойролцоо гороондоо гэртэй суудаг байсан. Сүүлийн үедээ энэ залуу лам нар гороондоо хонохгүй байна гээд арга хэмжээ ч авч л байсан. Тэгээд л удалгүй хийд тарсан даа.

Тэр үеийн лам нар номоо л хурна даа. Төгрөгийн хийдэд нэг жас байсан. Хийдэд цөөхөн лүйжинч, зодоч нар байсан. Зодын нэг дуган байсан. Гэрээр ч ном уншиж өгдөг байсан. Ухаан нь Гурван гүрэм гэдэг номыг дацангуудад зүгээр л нэг уншаад өнгөрчих юм. Миний багш бол гүрэмч хүн байсан. Тэр айлд нь очоод айлаасаа долоон төрлийн юм авч байж угаалганд нь хийдэг ёстой юм.

Манай хийдээс олон лам баригдсан. Ном шүтээнийг нь хураагаад хийд үгүй болсон байсан. Дуганын модоор хувийн байшин сав бариад тэгээд дуусгачихсан.

Тэр үеийн лам хуврагын өдөр тутмын амьдрал олон түмний сэтгэлээр, буян үйлдэх тийм юманд л амьдарч байсан юм. Одооны лам нараас өөр. Одооны лам нар чинь гоё ганган хачин. Би Дашчойлинг анх байгуулж байхаас нь л байсан. Тэгэхэд жаахан байсан хүүхэд одоо ловон болоод байж байна. Би тэгээд Буяндэлгэрийг цорж лам болоход нь за баяр хүргэе баярлалаа гэж хэлсэн. Өдийхөн лам нар бидэнд аашлуулаад байж байсан. Тэгсэн одоо ийм том лам болоод бидний дээр сууж байна. Тэд нарыг ийм болтол нь хүлээгээд тэгээд хараад сууж байгаа чинь бидэнд заяа буян юм.